

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗАР**“НОМТОЙ МОНГОЛ” УРИАН ДОР “ҮНДЭСНИЙ БИЧИГ ҮСЭГ, НОМЫН БАЯР-2023”
НАМРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИОН БАЙГУУЛСАН АЖЛЫН ТАЙЛАН**

2023.10.03

Дархан-Уул аймаг

Зорилго, үндэслэл: Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хууль, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2012 оны 158 дугаар зарлигийг тус тус үндэслэл болгон “Үндэсний бичиг соёл, номын өдрүүд-2023” арга хэмжээг Дархан-Уул аймгийн хэмжээнд тэмдэглэн өнгөрүүлж, бүх нийтийн уншлагыг дэмжих, номын сангийн өв санг арвижуулах, хүүхэд залуусын сурах эрмэлзэлд дэмжлэг үзүүлэх, ном эрдмийг түгээн дэлгэрүүлэхэд оршсон.

Үйл ажиллагааг зохион байгуулсан хугацаа, бүрэлдэхүүн: Батлагдсан удирдамжийн дагуу аймгийн Соёл, урлагийн газраас удирдлага арга зүйгээр хангаж, Төв номын, Хүүхдийн номын ордон, Хонгор, Орхон, Шарын гол сумдын Соёлын төвүүд 2023 оны 09 дүгээр сарын 15-наас 22-ныг өдрийг хүртэл хугацаанд зохион байгууллаа.

Зохион байгуулсан арга хэмжээнүүд:

2023 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр Номын баярын нээлтийг Залуучууд театрт 11:00 цагт аймгийн соёл, урлагийн газар, Залуучууд театр, Төв номын сан хамтран зохион байгууллаа. Тус баярын нээлтээр Төв номын сан 2022-2023 онд хамгийн их ном уншсан уншигч сурагчид, анги хамт олон, шилдэг номын санчийг тус тус шалгарууллаа.

2023 оны Тэргүүний уншигч, Д.Нацагдорж тэмдэгтэнээр 4 дүгээр багийн иргэн Ганхуягийн Ган-Од, ШУТИС-ийн лицей 12а ангийн сурагч Ганхуягийн Бөртүжин, 30 дугаар сургуулийн 11 ангийн сурагч Алдархишигийн Хишигтэй нар шалгарч шагналыг Соёл, урлагийн газрын дарга Х.Соёл-Эрдэнэ, Төв номын сангийн дарга Б.Цэцэгсүрэн нар гардууллаа.



Зураг: 1, 2- Шалгарсан сурагчдад шагнал гардууллаа. /2023.09.15/



Зураг: 3, 4- Тэргүүний уншигч анги хамт олноор:
18дугаар сургуулийн Т.Ариунсанаа багштай 5а, 9 дүгээр сургуулийн Ц.Ууганцэцэг багштай
116 ангийн хамт олон тус тус шалгарсан.



Зураг: 5,6- 2023 онд ангиараа хамгийн их ном уншсан ОИЦ сургуулийн 5-6 ангийг гарын бэлэг, талархал, шилдэг номын санчаар ОИЦ сургуулийн номын санч Г.Отгонжаргал шалгарч цомын эзэн боллоо.

ХЭЛЭЛЦҮҮЛЭГ:

Төрт ёс, хаадын сан Монголын утга зохиол судлалын төвийн тэргүүн, Монгол Улсын Шинжлэх ухааны Академийн хүндэт профессор, зохиолч, орчуулагч, түүх судлаач Д.Гүн-Үйлс “**Үеэс үед өвлөгдөх их дээдсийн судар**” сэдэвт хэлэлцүүлэг, сургалтыг 2023 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр Залуучууд театрын дугуй зааланд оюутан, багш нарын дунд зохион байгууллаа.



Зураг: 7, 8- “Түмэн засагт хаан” сэдвээр илтгэлийг ХААИС-ийн түүх нийгмийн багш Ц. Мөнхзул, Монгол хаад 3 боть “Өгөөдэй хаан” сэдвээр ШУТехнологийн их сургуулийн Түүх, нийгмийн багш Д.Дунгаамаа нар тус тус илтгэл тавьж бяцхан гарын бэлгээр шагнууллаа. /45 хүн оролцсон/

УУЛЗАЛТ:

“Тэнгэрийн заадаст оршихуй” зохиолч уран бүтээлчид 2023 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн 17:00 цагт Залуучууд театрын их танхимд Дархан хотын **315** иргэдтэй уулзалт хийж, өөрсдийн уран бүтээлийн тухай, хүүхэд залууст амьдралын сургамж, зөвлөгөөг өгч, соёл урлагийг сонирхогч хүүхэд залуусын хүсэл эрмэлзлийг сэргээсэн сонирхолтой, халуун дотно яриа өрнүүлсэн уулзалт болсон юм.



Зураг: 9, 10- Монгол Улсын Ардын зураач, УГЗүтгэлтэн, шог зураач Ц.Байды, Монгол Улсын Ардын жүжигчин Г.Мягмарнаран, МУСГЗ, Сэтгүүлч, зохиолч Ш.Ёолк, “Тэнгэрийн заадас” хөрөг номын зохиолч Ж.Буд-Эрдэнэ нар оролцлоо.

Хүүхдийн номын ордон уншигч хүүхэд багачуудыг номд дуртай болгох, ном унших арга барилд төлөвшүүлэх, зохиолч уншигчдын амьд харьцааг бий болгох зорилгоор Д.Нацагдоржийн шагналт, хүүхдийн зохиолч О.Сундуйтай уншигч хүүхдүүд, номын санч, багш нарийн төлөөлөлтэй уулзах уулзалт, лекцийн арга хэмжээг зохион байгуулж, нийт **220** гаруй уншигчийг хамруулсан.



Зураг: 11, 12- Д.Нацагдоржийн шагналт, хүүхдийн зохиолч О.Сундуйтай уулзлаа. /2023.09.19/

Аймгийн Төв номын сан нь Цэцэрлэг, Их сургууль, ЕБС-ийн Номын клуб, "Ид шидийн орон төслийн баг" нийт 65 гишүүдтэй **номын клубын** уулзалт хийлээ. Тус уулзалтаар санал бодлоо солилцож цаашид номын сантай болон клуб хоорондоо хэрхэн хамтран ажиллах талаар яриаг өрнүүлсэн юм.



Зураг: 13, 14- Аймгийн Төв номын сангийн зүгээс номонд хайртай уншигч сурагчид болон байгууллагын номын клубуудад номын хандив өргөн урамшууллаа. /2023.09.17/

БОЛОВСРОЛЫН ХӨТӨЛБӨР:

2023 оны 9 дүгээр сарын 16-ны өдөр Номын баярыг тохиолдуулан "Оюунлаг" ЕБС-ийн 11 дүгээр ангийн 65 хүүхэд, багш нарын хамт Дархан хоттой танилцахын сацуу Төв номын сангийн "Монгол бахархал" боловсролын хөтөлбөрт хамрагдлаа.



Зураг: 15, 16- Мөн номын талаарх сэтгэгдлээ хуваалцсан 4 сурагчид талархал, ном гардуулав.

НОМЫН СОЛИЛЦОО

2023 оны 09 дүгээр сарын 15, 16-ны өдрүүдэд үргэлжилсэн номын баяраар ЕБС-ийн сурагчид өөрт хэрэгцээтэй номоороо солилцох үйл ажиллагааг явууллаа. 38 хүүхэд 450 гаруй боть номоор оролцож, 160 орчим номоо худалдан борлуулж, солилцлоо.



Зураг: 17, 18-. Номын солилцоо явагдаж байна. /2023.09.15/

НОМЫН ХУДАЛДАА:

Номын баярын өдрүүдээр Америкийн соёл мэдээллийн төв, Эрүүл мэндийн газар, Их дээд сургууль-3, ЕБ-ын 6 сургууль, СӨБ-ын 1 дүгээр бүсийн хамт олон, “Ид шидийн орон” төслийн баг, Төрт ёс хаадын сан ТББ зэрэг нийт 14 байгууллага номын худалдаа явуулж 650 хүнд үйлчиллээ.



Зураг: 19, 20- “Монгол Хаад, Хатад” номын худалдааг өргөнөөр худалдаалж байна. /2023.09.15/



Зураг: 21, 22 – СӨБ болон Ид шидийн орон төслийн багийн номын худалдаа. /2023.09.15/

ҮЗЭСГЭЛЭН:

Залуучууд театрт Номын баярын нээлтээр ЕБС-ийн сурагчдын сурах бичгийн үзэсгэлэн, Төв номын сангаас Үнэт ховор номын үзэсгэлэн, ХАА салбарын шинэ ногооны үзэсгэлэн, 30 дугаар сургуулиас Үндэсний бичиг соёлоо түгээн дэлгэрүүлж монгол бичгийн хуйлмал номын үзэсгэлэн, Ид шидийн орон төслийн багаас тус тус үзэсгэлэнг гаргалаа. Нийт 250 иргэд, олон нийтэд үйлчлүүлээ.



Зураг: 23, 24- ,ЕБС-ийн сурах бичгийн үзэсгэлэн, Үндэсний бичиг үсгийн үзэсгэлэнг гаргалаа. /2023.09.15/



Зураг: 25, 26- , аймгийн Төв номын сан болон Ид шидийн орон төслийн багаас үзэсгэлэн гаргалаа. /2023.09.15/

ЧАНГА УНШЛАГА

Аймгийн Төв номын сан, Хүүхдийн номын ордон, сумдын соёлын төвүүд Номын баярыг тохиолдуулан ЕБС-ийн сурагчдын дунд чанга уншлагыг зохион байгуулллаа. Нийт 641 хүүхэд, залуучуудыг хамруулсан.



Зураг: 27, 28- ЕБС-ийн сурагчдыг чанга уншлагад хамрууллаа. /2023.09.17/

НОМЫН ХАНДИВ:

Аймгийн төв номын сан номын баяраар алслагдсан баг болох Малчин багийн иргэдэд зориулан 300 орчим боть номыг гардуулан өглөө. Тус баг нь иргэдийнхээ санаачлагаар соён гэгээрүүлэх ажлын хүрээнд багийн төвдөө номын сантай болж байгаа юм. Мөн Хонгор сумын Соёлын төвөөс Хонгор сумын 1 дүгээр багт оршин суудаг 7 ахмадууддаа хуучны уран зохиолын номнуудаас нийт **34 боть** номыг хандивлалаа. Мөн аймгийн Соёл, урлагийн газрын хамт олон номын баяраар төв номын санд 37 боть ном хандивласан юм.



Зураг: 29, 30- Номын сангийн хандив ном Номын баяраар үргэлжиллээ. /2023.09.15-17/

ШИНЭЭР САНААЧЛАН ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖИЛ:

“Чихтэй шувууны садан” шинэ номын нээлт 2023 оны 09 дүгээр сарын 11-ний өдөр аймгийн Төв номын санд боллоо. Зохиогч Ө.Рагчаасүрэн шинэ номоороо чихтэй шувууны садан, номын нөхдийг уншигчидтайгаа уулзуулсан бөгөөд Тэдэн дотор багш, зураач, уран дархан, зохиолч, найрагч, эмч, сэтгүүлч, тариаланч, инженер, хуульч гээд янз бүрийн ажил төрлийн хүмүүс орсон юм.



Зураг: 31, 32- СГЗүтгэлтэн, Зохиолч Ө.Рагчаасүрэнгийн шинэ номын нээлтэд нийт 45 хүн оролцлоо. /2023.09.11/



Зураг: 33, 34- “Шилдэг хандивлагч” болон “Шилдэг хамтран ажиллагч” иргэдийг урамшуулаа. /2023.09.15/

Аймгийн Төв номын сангаас уншигчдадаа мэдээлэл өгөх зорилгоор "Номтой Монгол" сонинг бэлтгэн, сар тутам гаргахаар болж эхний дугаараа 9 дүгээр сард зохион байгуулагдсан ажлуудыг эмхэтгэн аймгийн иргэд, олон нийт, сумдын иргэдэд хүргэж ажиллалаа.

МЭДЭЭЛЭЙН ТҮГЭЭЖ, СОЁЛЫН ӨВТҮҮЛЭЭ

НОМТОЙ МОНГОЛ

2023.09 сар

ДАРХАН-УУЛ АЙМАГ ТӨВ НОМЫН САГ

Уншигчдад илтгэл зурас

Нэг бүр номын баярыг өнгөрсөн үрэн хөндөгч "Номтой Монгол" нь биеийнхэн ажил илгээх үрэн 34 дэлгэцтэй Удсангийн номын баярыг өнгөрсөн үрэн хөндөгч ажиллагааг өнгөрүүлж, нэмсэн соёл, үзэл, сэтгэлгээний амжилтуудыг зохион байгуулж, Түргүүлж уншигчдад амжилтуудыг үргэлжлүүлэн өгөх ажиллагааг өнгөрүүлж байна. Номын баярыг бие бүр хөндөгч нь үрэн хөндөгч бөгөөд бие бүр хөндөгч нь нэмсэн соёл, үзэл, сэтгэлгээний амжилтуудыг зохион байгуулж, Түргүүлж уншигчдад амжилтуудыг үргэлжлүүлэн өгөх ажиллагааг өнгөрүүлж байна. Номын баярыг бие бүр хөндөгч нь үрэн хөндөгч бөгөөд бие бүр хөндөгч нь нэмсэн соёл, үзэл, сэтгэлгээний амжилтуудыг зохион байгуулж, Түргүүлж уншигчдад амжилтуудыг үргэлжлүүлэн өгөх ажиллагааг өнгөрүүлж байна.

“ХИЛ ХЭНГ АРГАЙН НОМЫН САГ” ТӨСВИЙН БАГ ДАРХАН-УУЛ АЙМАГТ АЖИЛЛАЛАА

Уншигчдын хүргэлт бэлд хамгийн их уншигчдын номын жагсаалт

1. Динэр-490,
2. Оюун-486,
3. Цэцэглэн-499,
4. Өрөөл-392,
5. Цойлог-379,
6. Г.М. 106-323,
7. Агуйн хэл өнгөрөх сурвалж-289,
8. Адуулагч зэрэг-281,
9. Ардын хүргэлт Мэлхийн-248,
10. Сурвалж-327.

МАЧГИЙН БАГ НОМЫН САНТАЙ БОЛНО.

Бид 33 дэх удамгийн Удсангийн номын баярыг Дархан сумын 15 дугаар багийн иргэдэд зориулж суртал, номын сангийн төлөөлд нь 300 орчим бичиг ном бэлтгэж байсан бөгөөд Эцэс нь хамгийн "НОМЫН БАЯР" - НОМТОЙ МОНГОЛ" 34 дэх удамгийн Удсангийн номын баярыг өнгөрсөн үрэн хөндөгч ажиллагааг өнгөрүүлж байна. Номын баярыг бие бүр хөндөгч нь үрэн хөндөгч бөгөөд бие бүр хөндөгч нь нэмсэн соёл, үзэл, сэтгэлгээний амжилтуудыг зохион байгуулж, Түргүүлж уншигчдад амжилтуудыг үргэлжлүүлэн өгөх ажиллагааг өнгөрүүлж байна.

“НОМЫН БАЯР - НОМТОЙ МОНГОЛ” БОРООТОН Ч, БОЛЗООТОН ӨДӨР

Эцэс нь нэг бүр номын баярыг өнгөрсөн үрэн хөндөгч ажиллагааг өнгөрүүлж байна. Номын баярыг бие бүр хөндөгч нь үрэн хөндөгч бөгөөд бие бүр хөндөгч нь нэмсэн соёл, үзэл, сэтгэлгээний амжилтуудыг зохион байгуулж, Түргүүлж уншигчдад амжилтуудыг үргэлжлүүлэн өгөх ажиллагааг өнгөрүүлж байна.

ДАРХАН-УУЛ НОМЫН БАЯРА ТЭМЦЭГЭЖ БАЙНА

Номын баярыг өнгөрсөн үрэн хөндөгч ажиллагааг өнгөрүүлж байна. Номын баярыг бие бүр хөндөгч нь үрэн хөндөгч бөгөөд бие бүр хөндөгч нь нэмсэн соёл, үзэл, сэтгэлгээний амжилтуудыг зохион байгуулж, Түргүүлж уншигчдад амжилтуудыг үргэлжлүүлэн өгөх ажиллагааг өнгөрүүлж байна.

НОМЫН САВЧИЙН “ХИШГЭЭ”

Номын баярыг өнгөрсөн үрэн хөндөгч ажиллагааг өнгөрүүлж байна. Номын баярыг бие бүр хөндөгч нь үрэн хөндөгч бөгөөд бие бүр хөндөгч нь нэмсэн соёл, үзэл, сэтгэлгээний амжилтуудыг зохион байгуулж, Түргүүлж уншигчдад амжилтуудыг үргэлжлүүлэн өгөх ажиллагааг өнгөрүүлж байна.

Зураг: 35, 36- Номтой Монгол шинэ дугаарын сонингоо гарган хэвлүүлээ. /2023.09.22/

Хүүхдийн номын ордон нь Номын баяраа угтан “**Номтой аялал**”, “**Байгальд уншъя**” зэрэг арга хэмжээг зохион байгуулж **280** сурагчдыг хамрууллаа.



Зураг: 35, 36- Байгальд гарч оюун ухаанаа тэллээ. /2023.09.16/

“АХА” ХӨГЖӨӨНТ ТЭМЦЭЭН УРАЛДААН:

2023 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр Номын баяраар 9 дүгээр сургуулийн 10д ангийн 31 сурагчдын дунд танин мэдэхүй аха тэмцээнийг зохион байгууллаа.



Зураг: 37, 38- 10д ангийн сурагч Б.Мөнгөнсарнай бусдыгаа хошуучлав. Ивээн тэтгэсэн Төрт ёс, хаадын сан ТББ-н хамт олондоо маш их баярлалаа.

ДҮГНЭЛТ:

"НОМЫН БАЯР- НОМТОЙ МОНГОЛ" уриан дор зохион байгуулагдсан “Үндэсний бичиг соёл, номын өдөр”-ийн баярын нээлт 2023 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 11:00 цагт Залуучууд театр зохион байгуулагдаж нээлтээр зохиолч, орчуулагч, түүх судлаач Д.Гүн-Үйлс өөрийн бүтээл "Монгол хаад, хатад" боть номоороо зорин ирсэн бол аймгийн Гэрлэх ёслолын ордон, “Америкийн соёл мэдээллийн төв”, Эрүүл мэндийн газар, Их дээд сургууль- 3, ЕБ-ын 6 сургууль, СӨБ-ын 1 дүгээр бүсийн хамт олон, “Ид шидийн орон”

төслийн баг, Төрийн болон төрийн бус байгууллагууд, Бийрийн дугуйлангийн сурагчид зэрэг 21 байгууллага оролцож өөр өөрсдийн өнгө төрхийг илэрхийлсэн номын үзэсгэлэн, ном товхимолын танилцуулга, бүтээлээ өргөн дэлгэж сурталчлан таниулж оролцлоо.

Намрын 34 дэх номын баяраар харьяа соёлын байгууллагууд 2023 оны 09 дүгээр сарын 17-оос 22-ны өдрийг дуустал **35** нэр төрлийн **66** үйл ажиллагаанд /давхардсан тоо/-оор **6255** хүнийг хамруулан ном хэвлэл, соёл олон нийтийн ажлыг зохион байгуулж цахимаар **4677** хүнд хүргэн, соёлын боловсролыг сурталчлан таниулж ажиллалаа.

Мөн 35 гаруй нэр төрлийн 4675 гаруй тараах материал, 1153 нэр төрлийн 2553 боть номоор үзэсгэлэн гаргаж номын худалдааг зохион байгуулав.

Тус баярын нээлтийн урлагийн арга хэмжээнд Залуучууд театрын дэргэдэх Дионис драмын жүжгийн дугуйлан, 1 дүгээр сургуулийн 5 анги, Од цогцолбор сургуулийн 5-6 анги, Хонгор, Орхон сумын Соёлын төвийн хамт олон, 18 дугаар сургуулийн Т.Ариунсанаа багштай 5а анги тус тус оролцлоо.

ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ САНАЛ:

Номын баярыг ирэх жилд зохион байгуулахад Улаанбаатар хотын Үндэсний төв номын сангаас өдрийг зөрүүлж хөдөө орон нутагт зохион байгуулах.

Тодорхой хэмжээний санхүүгийн дэмжлэг байвал орчноо бүрдүүлэх, хүнээ татахад орон нутагт чухал ач холбогдолтой байна.

ХЯНАСАН:

СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН ДАРГА

Х.СОЁЛ-ЭРДЭНЭ

ТАЙЛАНГ НЭГТГЭСЭН:

СОЁЛ, ГЭГЭЭРЛИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН Б.ДОЛГОРМАА